1.6. Дотоод аудитын ажилтан үүрэгт ажлаа гүйцэтгэхдээ Сангийн яам болон Улс, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтсээс шаардлагатай баримт бичгийн эх хувь, компьютерийн санах ойд байгаа мэдээллийн бүртгэл, тэдгээрийн гаргалт, үнэлгээ болон бусад шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд гаргуулан авна.

1.7. Дотоод аудит явуулахтай холбоотой баримт бичиг, мэдээлэл, тайлбарыг гуравдагч этгээдээс гаргуулж авах, шаардлагатай бол бусад баримт бичиг материалыг цуглуулах, дотоод аудитад хамрагдаж байгаа байгууллага, нэгжийн удирдлага эсвэл түүний эрх олгосон ажилтнаас шаардлагатай баримт материалыг хүлээн авах, тайлбар нэмэлт мэдээлэл гаргуулах, ажилтнуудыг татан оролцуулах эрхтэй байна.

1.8. Дотоод аудит явуулах зорилго, хамрах асуудал, хугацаа зэргийг багтаасан ажлын удирдамжийг аудит хийлгэж байгаа нэгжид танилцуулах, аудит хийхтэй холбогдуулан авсан баримт бичиг, эрх зүйн акт болон бусад материалыг буцаан өгөх, дотоод аудитын үр дүн, хяналтын явцад илрүүлсэн зөрчлийн талаар аудитад хамрагдаж байгаа нэгжээс санал зөрүүтэй байвал бичгээр тайлбар авах, аудитын тайлан, хийсэн шалгалт, гаргасан дүгнэлтийн үнэн зөвийг бүрэн хариуцах заасан ёс зүйн хэм хэмжээг баримтлах үүрэгтэй.

1.9. Дотоод аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, үр дүнг тайлагнах, аудитын мөрөөр авах арга хэмжээ гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэнэ.

Хоёр. Аудитын төлөвлөлт

2.1. Дотоод аудит, хяналт-шинжилгээний нэгж нь дотоод аудитыг төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн эрсдлийн үнэлгээнд үндэслэн төлөвлөнө.

2.2. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөл гарах, эсвэл төрийн байгууллагын ажлын гүйцэтгэл нь тогтоосон зорилго, зорилтууд, стандартаас хазайх магадлалыг эрсдэл гэнэ.

2.3. Дотоод аудитын төлөвлөгөөг үнэн зөв, бодитой, оновчтой боловсруулах зорилгоор төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийнэ. Уг эрсдлийн үнэлгээг үндэслэн дотоод аудит хийх дараалал, дотоод аудитын зорилго, хамрах хүрээг тогтоох бөгөөд үргэлжлэх хугацаа нь тухайн ажлын цар хүрээнээс хамаарна.

2.4. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод, гадаад эх үүсвэрээс учирч болох эрсдэлийг дотоод хяналтаар үнэлнэ. Эрсдлийг тодорхойлоход тоо, чанарын талаас нь зэрэглэх, урьдчилсан төсөөлөл буюу хэтийн төлөвлөлт, аудитын дүгнэлтийг судлах аргуудыг хэрэглэнэ.

2.5. Эрсдэлийг "Аудитын олон улсын стандарт 400"-д заасны дагуу үнэлнэ.

2.6. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд төсвийн орлого, зарлагын тооцоололт, гадаад зах зээлийн үнэ, валютын ханшийн өөрчлөлт, норм нормативыг буруу тооцох зэргээс эрсдэл, алдаа гардаг болохыг харгалзан дүгнэлт өгнө.

2.7. Дотоод аудитын жилийн төлөвлөгөөг үндэслэн, дотоод аудит явуулах ажилтнууд аудитын үйл ажиллагааны удирдамжийг энэ зааврын 1 дүгээр хавсралтын дагуу боловсруулж, удирдлагаар батлуулна.

2.8. Дотоод аудит эхлэхийн өмнө ажлын хэсэг урьдчилсан судалгаа хийж, мэдээлэл цуглуулсан байх шаардлагатай. Үүнд,

Дотоод аудитад хамрагдаж буй нэгжийн:

- Үйл ажиллагааны зорилго зорилтыг тодорхойлсон хөтөлбөр, баримт бичгүүд, холбогдох хууль тогтоомж, журам заавар;
- Зохион байгуулалтын бүтэц, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь;
- Хяналтын систем, эрсдэлийн удирдлага, тайлагнах механизм зэргийг судлан үзнэ.

Энэ нь тухайн нэгжийн үйл ажиллагаа, түүний эрсдэл, хяналттай танилцаж, онцгой анхаарал хандуулах хэсгийг тодорхойлох, дотоод аудитыг явуулахад ашиглах мэдээллийг олж авах ач холбогдолтой.

Гурав. Дотоод аудитын төрөл, хамрах хүрээ

3.1. Улс, орон нутгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд явуулах дотоод аудитыг төлөвлөгөөт, гэнэтийн, тусгай гэсэн төрлөөр гүйцэтгэнэ.

3.2. Төлөвлөгөөт дотоод аудитыг урт хугацааны болон жилийн төлөвлөгөөний дагуу, гэнэтийн дотоод аудит нь үйл ажиллагааны онцлогоос хамааран, тусгай дотоод аудит нь цаг үеийн шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу гүйцэтгэнэ.

3.3. Дотоод аудитыг хамрах хүрээнийх нь хувьд иж бүрэн, хэсэгчилсэн, түүвэр байдлаар хийнэ.

3.4. Иж бүрэн дотоод аудит гэдэг нь төсвийн жилийн хугацааны, бүрэн хэмжээний, бүх чиглэлийн шалгалтыг хамруулан хяналт тавихыг хэлнэ.

3.5. Хэсэгчилсэн дотоод аудит гэдэг нь тухай үеийн гэнэтийн шаардлага, нөхцөл байдлаас хамааран тодорхой хугацааны, хянагдаж байгаа объектын болон үйл ажиллагааны тодорхой хүрээг хамруулан хэсэгчилсэн байдлаар хяналт тавихыг хэлнэ.

3.6. Түүвэрчилсэн дотоод аудит гэдэг нь шалгагдах объектоос сонголт хийж, гэнэтийн байдлаар, хязгаарлагдмал хүрээнд түүвэр хяналт тавихыг хэлнэ.

3.7. Дотоод аудитыг дараах хүрээг хамруулан явуулж болно. Үүнд:

- Төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, гүйцэтгэлийн дотоод аудит /хавсралт- 4/
- Төрийн сангийн дотоод аудит /хавсралт-5/
- Худалдан авах ажиллагааны дотоод аудит /хавсралт -6/
- Зээл тусламжийн ашиглалт, зарцуулалтын дотоод аудит
- Мэдээллийн технологийн дотоод аудит

3.8. Шаардлагатай гэж үзвэл дотоод аудитыг эхлэхээс өмнө нэгжийн үйл ажиллагаа болон дотоод аудитын явцад анхаарах асуудлуудын талаар хариуцсан газар хэлтсүүдээс санал авч болно.

3.9. Улс, орон нутгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаа нь өргөн хүрээг хамардаг учраас дотоод аудит явуулах зарим тохиолдолд холбогдох газруудаас мэргэжлийн баг бүрдүүлэн ажиллаж болно.

Дөрөв. Дотоод аудит явуулах хяналтын аргууд

4.1. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит явуулахдаа дараах хяналтын аргуудаас сонгож хэрэглэнэ.

4.2. **Урьдчилан судалгаа хийх** гэдэг нь тухайн үйл ажиллагаа, түүний эрсдэл, хяналттай танилцаж онцгой анхаарал хандуулах хэсгийг тодорхойлох, мэдээлэл цуглуулах, шалгагдах гэж байгаа зүйлийн талаар тодорхой ойлголт авах, шалгагдаж буй нэгжтэй уулзах, холбогдох хүмүүстэй ярилцлага хийх, удирдлагын тайлан, гаргасан судалгаатай танилцах зэрэг үйл ажиллагаа юм.

4.3. **Мэдээллийг цуглуулж хянах** дотоод аудитыг гүйцэтгэхийн өмнө тухайн шаардагдаж буй үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цуглуулж, хянан дүгнэлт өгөх шаардлагатай. Зорилтыг тодорхойлсон баримт бичгүүд, зохион байгуулалттай холбоотой мэдээлэл, шалгагдах нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, заавар, журмууд, тайлагнах механизм зэрэг асуудал орно. Мөн зорилго, зорилт, төлөвлөгөө, бичиг баримт, заавар, журамд орсон өөрчлөлт, төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, өмнөх аудитын баримт материал, мэргэжлийн холбоотой баримт бичиг хамаарна.

4.4. **Дотоод хяналтын системийн үнэлгээ** нь дотоод аудитын чухал хэсэг учраас шалгагдаж буй нэгжийн удирдлага нь дотоод хяналтын найдвартай сүлжээний системийг бий болгосон байна. Дотоод хяналт нь үйл ажиллагааны үр ашигтай, төсвийн төлөвлөлтийн үнэн зөв байдал, хууль тогтоомжид нийцсэн байдлыг үнэлэх ёстой. Ямар нэг ноцтой зөрчил, дутагдал, алдаа гарсан тохиолдолд мэдээллийг тэр дор нь авах тогтолцоотой байна.

4.5. **Ажиглалт, мэдээллийн арга** нь дотоод аудитад хамрагдаж буй нэгжийн ажлын зохион байгуулалт, ажилтнуудын ажил үүргийн хуваарь, идэвхи санаачлага, харилцагч байгууллага, иргэдийн санал, гомдол, мэдээлэл зэрэгт тулгуурлан тухайн нэгжийн үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж стандартын дагуу байгаа эсэхтэйхослуулан дүгнэлт өгнө.

4.6. **Асуулга хийх арга** нь дотоод аудит явуулж байгаа газар, хэлтэс нэгжүүдийн ажилтнууд болон болон бусад төсвийн харилцагчдаас төсвийн төлөвлөлт, санхүүжилт, тайлан балансын гаргалт, хүлээн авалт, дутагдал, доголдлын талаар шаардлагатай мэдээлэл олж авах зорилгоор асууж лавлах, тодорхойлолт авах, санал асуулга явуулах хэлбэрээр хийгдэнэ.

4.7. **Биет шалгалт буюу тооллого** нь ихэвчлэн үндсэн хөрөнгө, бараа материал, бэлэн мөнгө, үнэт цаас, өрийн бичиг, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын ажлын хэмжилт гэх мэт бодитой биет зүйл дээр шалгах болон тоолох замаар түүний бодитой оршин байгааг баталгаажуулна.

4.8. **Баримтын шалгалт хийх арга** нь дотоод аудитад хамрагдаж буй нэгжийн санхүүгийн бүртгэл, мемориалын ордер, мөнгөн хөрөнгийн гүйлгээний баримтууд, тайлан балансын үзүүлэлтүүд болон харилцагч байгууллагын төлбөр тооцоо гэх мэт баримтад хууль, тогтоомж болон Сангийн сайдын баталсан эрх

Батлагдсан

зүйн акт, аливаа шийдвэрийн хэрэгжилтийг шалгах чиглэлээр хийгдэнэ. Энэ нь ажил үйлчилгээг гүйлгээ тус бүрээр нягтлан шалгах арга юм.

4.9. **Тооцоолох арга** нь тооцооны арифметик үйлдлийг зөв хийсэн эсэхийг шалгах арга юм. Төсвийн төлөвлөлтөд энэ аргыг голчлон төсвийн орлогын нэр төрөл, зарлагын эдийн засгийн ангилал, хөрөнгө оруулалтын жагсаалт гаргахад хэрэглэж байгаа.

4.10. **Шинж тэмдгээр түүвэрлэх арга** нь ажил гүйлгээнээс тодорхой шинж чанартай ажил гүйлгээний хэсгийг тогтоох, нарийвчилсан сорил /сонголт/ явуулж, тооцоололоос алдаатай хэсгийг олж мэдэх, хяналт тавигдсан ба хяналт тавигдаагүйг олж мэдэх дотоод аудитуудын хэрэглэдэг арга юм. Бусад түүврийн аргуудыг хөндлөнгийн аудитын шалгалтад хэрэглэдэг.

4.11. **Шинжилгээний горимууд** нь эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн харьцаа, хандлага, статистик мэдээллүүдийг ашиглаж хэвийн бус эсвэл онцгой хазайлтуудыг судлаж үзэх арга юм. Энд маш олон үзүүлэлтийн харьцааг эдийн засгийн шинжилгээний сурах бичгийн номоос судлан хэрэглэнэ.

4.12. **Шинжилгээний аргууд** дотоод аудит хийх нь зөвхөн шалгаж эрсдлийг илрүүлэх бус цаашид эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаатай холбож үзвэл илүү үр ашигтай болох учраас дотоод аудитын ажилтнууд эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүтгэлийн шинжилгээний аргыг ашиглана.

4.13. Дотоод аудитын явцад тухайн салбар, нэгжид гарч болзошгүй өндөр эрсдлийг тодорхойлоход залилан, хуурч мэхлэх үзэгдэл гарсан эсэхэд анхаарах хэрэгтэй. Юуны өмнө хяналт сул хэсэгт гардаг уламжлалт хийгээд орчин үед нэлээд тохиолдох болсон бөгөөд түүнийг илрүүлэхэд яривагтай, хор уршиг нь харьцангуй их магадлалтайд тооцогддог компьютерийн цахим сүлжээг ашиглан гарах эрсдлүүдийг онцгой анхаарах хэрэгтэй.

Тав. Дотоод аудитын тайлагнал, ажлын баримт

5.1. Дотоод аудитын тайланг энэ журмын хавсралт 2 дугаарт заасан загвараар бичих бөгөөд дотоод аудитын зорилго, хугацаа, аудит явуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хамрагдсан байгууллагын нэр, хамарсан хүрээ, арга зүй, илрүүлсэн ололт, зөрчил дутагдал, дүгнэлт, зөвлөмж, цаашид авах арга хэмжээний санал болон хавсралт материалууд /аудитын ажлыг зохих ёсоор баталгаажуулсан баримт, холбогдох баримт бичгүүдийн хуулбар, тооцоо судалгаа, гэрэл зураг г.м/ зэргийг хамруулсан байна.

5.2. Ажлын баримт бичиг нь дотоод аудитын үед цуглуулсан материалыг цаашид лавлагаа болгон ашиглах, хийгдсэн шалгалт, гүйцэтгэсэн аудитын горимыг баримтаар нотлох, аудитын дүгнэлт болон үр дүнг баримтжуулах, шалгалтын тайланд дурьдсан санал дүгнэлтийг баталгаажуулах үйл ажиллагаа юм.

5.3. Ажлын баримт нь дотоод аудитыг бодитойгоор явуулахад чиглэгдэхээс гадна шалгалтын удирдамжид заасан хүрээг бүрэн хамарсан, илэрсэн зөрчил дутагдал, шамшигдуулалтыг нотлох баримтаар баталгаажуулсан, цаашид авах арга хэмжээний талаар тодорхой санал дэвшүүлсэн байна.

5.4. Дотоод аудитын тайлан нь

- Бодитой /баримтаар нотолсон, мушгин гуйвуулаагүй, аль нэг талыг баримтлаагүй/;
- Ойлгомжтой /зүй тогтол, эрэмбэ дараатай, шаардлагагүй мэргэжлийн үг хэллэг хэрэглээгүй/;
- Товч /илүү зүйлийг нуршихаас зайлсхийж, гол асуудлыг цөөн үгээр илэрхийлэх/;
- Үр дүнтэй /аудитад хамрагдсан нэгжийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн/;
- Хугацаандаа /тайлан бичилтийг шалтгаангүйгээр хойшлуулахгүй/ гарсан байх ба биелэгдэх боломжтой зөвлөмжүүд өгөгдсөн байна.

5.5. Дотоод аудитын тайланд дараах ерөнхий шаардлага тавигдана. Үүнд:

- Албан хэрэг хөтлөлтийн журам, зааварт нийцсэн, бичиг хэргийн стандартыг хангасан;
- Байгууллага нэгжийн нэрийг холбогдох эрхийн актад заасан албан ёсны нэрийг хэрэглэх;
- Хуудсыг дугаарласан байх;
- Ажлын хэсэг болон холбогдох хүмүүс бүгд гарын үсэг зурж баталгаажуулсан байх;
- Албан тушаал гарын үсгийн тайлалыг хийсэн байх.

5.6. Дотоод аудитын явцад хамрагдаж байгаа газар нэгжийн удирдлагаас тайланд орсон дүгнэлтэд санал нийлэхгүй асуудлаар тайлбараа бичгээр илэрхийлж болно.

5.7. Дотоод аудитын ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг аудит явуулсан байгууллага, нэгжийн удирдлага, холбогдох ажилтнуудад танилцуулж, тэмдэглэл үйлдэн, гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Зургаа. Дотоод аудитын дүнг танилцуулах

6.1. Дотоод аудит явуулсан тухай тайлан, ажлын баримтыг нэгтгэн дүгнэж, дүнг яамны удирдлагад танилцуулсны дараа **Дотоод аудитын зөвлөлийн** хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулна.

6.2. Дотоод аудитын дүнг зорилго, хамрах хүрээ, ерөнхий мэдээлэл, илэрсэн зөрчил, санал, дүгнэлт, зөвлөмж, дотоод аудитад хамрагдсан нэгжийн тайлбар зэргийг хамруулан танилцуулна.

6.3. Тайланг Дотоод аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулсны дараа холбогдох ажилтнуудад мэдээлнэ.

6.4. Дотоод аудит хийж байгаа ажилтан нь ажлын баримтад нууц мэдээллүүд байгаа бол нууцын тухай хуулийн заалтыг мөрдлөг болгож байгууллага, нэгжийн удирдлагад танилцуулан, Дотоод аудитын зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа шаардлагатай бол нийтэд мэдээлнэ.

Батлагдсан

6.5. Хууль, тогтоомж зөрчсөн нь гэмт хэргийн шинжтэй байвал Дотоод аудитын зөвлөлийн хурлын шийдвэрээр эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

6.6. Дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлын талаар хамрагдсан байгууллага, нэгж бүрээр зөрчлийг ангилж, энэ зааврын хавсралт-3 дугаарт заасан "Дотоод аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт"-аар нэгтгэн гаргаж тайлагнана.

6.7. Дотоод аудитын ажлын баримт нь архивын нэгж болно.

Долоо. Дотоод аудитын мөрөөр авсан арга хэмжээний хяналт

7.1. Дотоод аудитын зөвлөлийн хурлаас бодлого, шийдвэр, хөтөлбөр, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх талаар зөвлөмж гаргаж, Дотоод аудитад хамрагдсан байгууллага, нэгжид албан ёсоор хүргүүлнэ.

7.2. Байгууллага, нэгж нь дотоод аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, тайланд тусгагдсан зөрчил дутагдлыг засаж сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж биелэлтэд хяналт тавьж ажиллана.

7.3. Дотоод аудитын тайланд тусгагдсан зөрчлийг арилгах талаар удирдлагаас авах арга хэмжээ нь оновчтой, үр ашигтай, цагаа олсон байх шаардлагатай.

7.4. Дотоод аудитын зөвлөмжийг албан ёсоор хүргүүлснээс хойш тогтоосон хугацаанд шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний талаар Улс, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн газар, хэлтсээс мэдээлэл ирүүлнэ.

7.5. Дотоод аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар төлөвлөсөн ажлаа бүрэн биелүүлсэн тухай бүр мэдээлж байна.

---oOo---

*Дотоод аудит явуулах зааврын хавсралт-1
/Дотоод аудит явуулах удирдамжийн загвар/*

БАТЛАВ.
/албан тушаал, нэр/

.....–**НД ДОТООД АУДИТ ЯВУУЛАХ УДИРДАМЖ**

20.... онысарын-ний өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

Дотоод аудитыг ямар хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг үндэслэн явуулж байгааг бичнэ.

Хоёр. Аудитын зорилго

Энэ хэсэгт аудитын зорилгыг заана.

Гурав. Аудитын ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч болон гишүүдийн албан тушаал, нэрс

Дөрөв. Аудит хийх хугацаа

20..... оны дүгээр сарын-ны өдрөөс эхлэн ... хоногт багтаан гүйцэтгэнэ.

Тав. Хамрах хүрээ

Энэ хэсэгт ямар үйл ажиллагааг хамруулан аудит хийж байгааг бичнэ. Хавсралт 4-6 дугаарт заасан дотоод аудитын хамрах хүрээ чиглэлийг ашиглан бичих.

Зургаа. Аудитын дүнг тайлагнах

Энэ хэсэгт дотоод аудитын тайлангнал, тайлангийн бүрдүүлбэр, ямар хүрээнд тайлагнах, зэргийг зааж өгнө.

Долоо. Үүрэг хариуцлага

Дотоод аудит явуулах ажлын хэсгийн болон дотоод аудитад хамрагдаж байгаа нэгжийн эрх үүргийн талаар бичнэ.

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,

Батлагдсан

ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

Дотоод аудит явуулах зааврын хавсралт-2
/Дотоод аудитын тайлангийн загвар/

/Тайлангийн нүүр/

/Байгууллагын нэр/

_____ -нд
/хамрагдсан нэгж, эсвэл үйл ажиллагааны нэр/
ДОТООД АУДИТ ЯВУУЛСАН ТАЙЛАН

Дотоод аудит, хяналт-шинжилгээ,
үнэлгээний газар

/Аймаг, хотын нэр/

... оны ... дүгээр сарын ...-ны өдөр
**НЭГ. АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ,
АРГА ЗҮЙ**

1.1. Аудитын зорилт

Дотоод аудитын зорилго, түүний хүрээнд ямар чиглэлүүдээр ажилласан талаар бичнэ.

1.2. Хамарсан хүрээ

Энэ хэсэгт дотоод аудитын үйл ажиллагааны хамарсан хүрээ, хугацааг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд дотоод аудитад хамрагдаагүй үйл ажиллагааны хүрээг зааж өгөх хэрэгтэй.

1.3. Арга зүй

Энэ хэсэгт аудитыг гүйцэтгэхдээ ямар ямар аргазүйг ашигласан талаар дурдана.

1.4. Ерөнхий мэдээлэл

Тайланг ойлгомжтой байлгахын тулд дотоод аудитын ажлын хэсэг тайландаа зарим ерөнхий мэдээллийг оруулж болно. Энэ мэдээлэл нь аудитад хамрагдсан нэгж, түүний үйл ажиллагаа, өмнө дотоод аудит явагдаж байсан бол илэрч байсан ололт, зөрчил, өгсөн дүгнэлт, зөвлөмж, түүний хэрэгжилтийн байдал зэрэг мэдээллийг агуулсан байж болно.

**ХОЁР. ДОТООД АУДИТААР ИЛЭРСЭН ОЛОЛТ,
ЗӨРЧЛИЙН ТАЛААР**

Дотоод аудитын явцад илэрсэн ололт, алдаа дутагдлын талаар энэ хэсэгт тусгана. Үүнд:

- *Дотоод аудитын хамарсан хүрээнээс шалтгаалан энэ хэсгийг нэг буюу хэд хэдэн хэсэгт бүлэглэн бичиж болно. Тухайлбал, төсвийн орлогын болон зарлагын төлөвлөгөө гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт ... г.м*
- *Хууль тогтоомжийн хэрэгжилт*
- *Илэрсэн зөрчил дутагдал нь ямар хууль эрхийн актын ямар заалтыг зөрчсөн тухай*
- *Зөрчил дутагдал гарсан үндсэн шалтгаан, хор хохирол, цаашид гарч болзошгүй эрсдэл, түүнээс сэргийлэх талаар тухайн нэгжийн зүгээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тухай зөрчил дутагдал давтагдаж байгаа эсэх*
- *Шаардлагатай гэж үзвэл илэрсэн зөрчлүүдийг нотлох баримтын хуулбар, гэрэл зураг, бусад төрлийн баримт*
- *Шалгуур үзүүлэлт болон бодит байдлын зөрүү*
- *Дотоод аудитад хамрагдсан нэгж хэсэгт ажлын ололт амжилт, бусад ижил төрлийн байгууллага нэгжид авч хэрэгжүүлэхүйц туршлага байгаа бол энэ хэсэгт бичиж болно.*

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Ажлын хэсэг дотоод аудитаар илрүүлсэн зүйлсдээ үндэслэн дүгнэлт бичнэ.

Ажлын хэсгийн дүгнэлтэд дотоод аудитаар илрүүлсэн дутагдалтай болон ололттой тал, тэдгээрийн улс, орон нутгийн төсөв санхүүгийн үйл ажиллагаанд болон тухайн нэгжийн үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөлөл, төсвийн болон зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт зарцуулалтын байдал, дотоод аудитад хамрагдсан нэгжийн ажлын зохион байгуулалт, сахилга хариуцлага зэргийг ажлын хэсгийн зүгээс өгсөн үнэлгээг тусгана.

Дүгнэлт хэсэг нь товч, тодорхой байвал зохино.

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ

Ажлын хэсэг дотоод аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн санал, зөвлөмжийг гаргана.

Зөвлөмж нь төсвийн болон зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, дотоод аудитад хамрагдсан нэгжийн үйл ажиллагааг сайжруулах, бусад ижил төстэй байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд нийтлэх анхаарах асуудал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой тусгасан, хэрэгжихүйц, ажил хэрэгч, тодорхой нэгж, албан тушаалтанд хандсан шинжтэй байна.

ТАВ. ТАЙЛАНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ

Дотоод аудитын тайланг боловсруулж дууссаны дараа ажлын хэсгийн бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулж, Дотоод аудит, хяналт-шинжилгээний нэгжийн дарга, орлогч дарга нар хянан, гарын үсэг зурсны дараа тайланг яамны удирдлагад албан ёсоор танилцуулна.

Мөн шаардлагатай гэж үзвэл Дотоод аудитад хамрагдсан нэгжийн дарга, удирдлага буюу холбогдох албан тушаалтнаар танилцан зөвшөөрсөн тухай баталгаажуулж, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж болно.

---oOo---

**ДОТООД АУДИТААР ИЛЭРСЭН
ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн нэр	Баигууллагын нэр		Дүн
1. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого бүрэн шилжүүлээгүй			
2. Төсвийн зарлагын төлөвлөлтийн нормативын эрсдэл			
3. Батлагдсан төсвийн орлого дутуу оруулсан			
4. Төсвийн зарлага санхүүжилт хэтрүүлсэн			
5. Баримтын бүрдэл дутуу байхад гүйлгээ хийсэн			
6. Хөрөнгө оруулалтын хийгдээгүй ажилд санхүүжилт олгосон			
7. Зориулалтын бус зүйлд санхүүжилт олгосон			
8. Төсвийн хөрөнгийг аж ахуйн нэгжийн дансанд байршуулсан			
9. Хэрэгцээнээс илүү бараа нөөцөлсөн			
10. Төсвийн хөрөнгөөс хууль бусаар зээл олгосон			
11. Дутагдал, шамшигдал гаргасан			
12. Өр, авлага үүсгэсэн			
13. Төсвийн зарлагын хэмнэлтийг буруу тооцсон			
14. Цаг үеийн арга хэмжээний төсөв хянаагүй байсан			
15. Бусад хууль тогтоомж зөрчсөн			

---oOo---

**ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
ДОТООД АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ /ЧИГЛЭЛ/**

Төсвийн орлого зарлагын төлөвлөлт, гүйцэтгэлийн дотоод аудитын хамрах хүрээ нь бүх шатны төсөвт байгууллага, Засгийн газрын тусгай болон нутгийн хөгжлийн сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлж байгаа этгээд, хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна.

Төсвийн орлого зарлагын төлөвлөлт, гүйцэтгэлд дотоод аудит явуулахдаа

- Нэгдсэн төсвийн тухай
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай
- Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай
- Тухайн оны төсвийн тухай хууль
- ЗГ-ын тусгай сангийн тухай
- Хүний хөгжил сангийн
- Татварын багц хуулиуд зэрэг төсөв санхүүгийн холбогдох хуулиуд
- Засгийн газрын тогтоол
- Сангийн сайдын тушаалаар батлагдсан төсөв, санхүүгийн холбоотой харилцааг зохицуулахаар гаргасан журам, дүрэм, заавар, мэргэжлийн байгууллагаас гаргасан норм норматив, шалгуур үзүүлэлтүүд зэрэг холбогдох бусад хууль эрхийн актын хүрээнд дараах байдлаар авч үзнэ.

1.1. Улсын төсвийн орлого төвлөрүүлэлт, төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсвийн төлөвлөлт, төсвийн хөрөнгийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилт, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байгаа эсэх, мөрдөгдөж буй хууль тогтоомж, заавар, журам, үүрэг даалгаврын хэрэгжилтийн байдал, төсвийн ил тод байдал, хяналт хэрхэн хэрэгжиж байгааг үнэлж, дүгнэн, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, удирдлагыг сайжруулах, эрсдэлийг бууруулах, илэрсэн зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгөх

1.2. Дээр дурдсан хуулиуд болон бусад санхүү, төсөв, татвар, нягтлан бодох бүртгэлийн мөрдөгдөж буй хууль тогтоомжууд, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журам зэрэг эрхийн актуудыг судлан үзэж, удирдамжид заасан үүргийг биелүүлэхэд зайлшгүй шаардагдах хууль эрхийн акт болон дотоод аудитад хамрагдах асуудлаа тодорхойлох.

1.3. Төсвийн орлого төвлөрүүлэлт, түүнтэй холбогдох харилцааны талаар дараах байдлаар авч үзнэ. Үүнд:

- 1.3.1. Улс орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улс орон нутгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх дунд хугацааны зорилттой тохирч байгаа эсэх;
- 1.3.2. Төсвийн орлогын тооцооллын үндэслэлийг өмнөх жилүүдийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл болон орлогод нөлөөлж болох

- бусад хүчин зүйлс /үнэ ханшийн өөрчлөлт, үйлдвэрлэл ба борлуулалтын өсөлт бууралт, экспорт импортын хэмжээ г.м/-тэй харьцуулан орлогын нэр төрөл бүрээр дүгнэлт өгөх;
- 1.3.3. Төсвийн орлогын гүйцэтгэлийг орлогын нэр төрлөөр авч үзэн дүгнэлт өгөх. /ААНОАТ, НӨАТ, ОАТ, ХХОАТ, Улсын тэмдэгтийн хураамж, АМНАТ, тусгай зөвшөөрлийн төлбөр, газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар, ногдол ашиг, хүү торгуулийн орлого болон хууль тогтоомжоор тогтоосон бусад орлого/;
 - 1.3.4. Улсын төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт, улсын төсвийн орлого төвлөрүүлэлт, гүйцэтгэлийг орлогын нэр төрлөөр нь авч үзэн дүн шинжилгээ хийх. /ААНОАТ, НӨАТ, ОАТ, улсын тэмдэгтийн хураамж, АМНАТ-70%, тусгай зөвшөөрлийн төлбөр-50%, ногдол ашиг, хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт орох бусад орлого г.м/;
 - 1.3.5. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг орлогын нэр төрлөөр нь үзэн дүн шинжилгээ хийх. /ХХОАТ, АМНАТ-30%, тусгай зөвшөөрлийн төлбөр-50%, газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар, ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого бусад албан татвар, төлбөр, хураамж/;
 - 1.3.6. Татварын бус орлогын тооцоолол, төвлөрүүлэлт, хяналт зохих журмын дагуу явагдаж байгаа эсэх;
 - 1.3.7. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн эрхзүйн үндэслэл, тооцоолол;
 - 1.3.8. Татварын буцаан олголтын тооцоолол, гүйцэтгэл;
 - 1.3.9. Татварын орлогын түвшинг татварын суурь үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэн тооцож, өнгөрсөн үетэй харьцуулан, анхаарал татахуйц хэлбэлзэл гарвал түүний шалтгаан, нөлөөллийг судалж, холбогдох тайлбар гаргуулах;
- 1.4. Төсвийн урсгал зарлагын төлөвлөлт, гүйцэтгэлийг дараах байдлаар авч үзнэ. Үүнд:
- 1.4.1. Төсвийн урсгал зардлын төлөвлөлтийн үндсэн үзүүлэлтийн тооцоолол, Улс орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улс орон нутгийн хөгжлийн дунд хугацааны стратеги, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудтай тохирч байгаа эсэхэд дүгнэлт өгөх. Төсвийн төлөвлөлтийн тоон болон чанарын үзүүлэлтийг хэрхэн харгалзсан байдлыг салбар тус бүрээр тооцож төлөвлөлтөд ашигласан байдал;
 - 1.4.2. Төсвийн удирдлага, зарцуулалт, гүйцэтгэл, хяналтын байдалд дүгнэлт өгөх;
 - 1.4.3. Төсвийн хууль, тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд дүгнэлт өгөх;
 - 1.4.4. Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тооцооллыг хянах;
 - 1.4.5. Төсвийн зарлагын норм, нормативын мөрдөлт;
 - 1.4.6. Хэрэгжиж дууссан арга хэмжээний төсөв дараагийн жилд хасагдаж хянагдсан эсэх;
 - 1.4.7. Шинээр эхлэх арга хэмжээний төсвийн тооцоололын үнэн бодиг эсэх;

Батлагдсан

- 1.4.8. Төсвийн ерөнхийлөн захирагчдын бүтээгдэхүүн, хөтөлбөрт суурилсан төсвийн тооцоолол, өртөг тооцолт;
 - 1.4.9. Орон тоо, цалингийн сангийн тооцоолол, схемийн мөрдөлт;
 - 1.4.10. Төсвийн тогтмол зардлын тооцоолол, үнийн өсөлтийг харгалзсан байдал;
 - 1.4.11. Салбарын онцлогтой холбогдсон төсвийн тооцоололд хэрэглэгдэх хууль эрхийн актуудын биелэлт;
 - 1.4.12. Төсөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх, хэмнэлтийн горим баримтлан санхүүжилтийн тооцоо хийж байгаа эсэх;
 - 1.4.13. Нийгмийн даатгалын болон Хүний хөгжлийн сангуудын санхүүгийн үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа;
 - 1.4.14. Засгийн газрын тусгай сан, нөөц хөрөнгө, хуваарилагдаагүй зардлын ашиглалт зарцуулалт зохих хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэх;
 - 1.4.15. Төсвөөс аж ахуйн нэгжид олгож байгаа татаас, санхүүгийн дэмжлэгийн олголт;
 - 1.4.16. Орон нутгийн төсвийн хөрөнгийн хуваарилалт, удирдлага, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй үр ашигтай, хууль тогтоомжийн дагуу зарцуулж байгаа эсэхэд дүгнэлт хийх;
 - 1.4.17. Бараа үйлчилгээний зардал, зээлийн төлбөр болон бусад татаас шилжүүлгүүд цаг хугацаандаа, графикийн дагуу хийгдэж байгаа эсэх;
- 1.5. Төсвийн хөрөнгө оруулалтын зардлын ашиглалт зарцуулалтыг дараах байдлаар авч үзнэ. Үүнд:
- 1.5.1. Энэхүү хавсралтын 1.1, 1.2-т заасан хууль тогтоомжуудын хэрэгжилт болон Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар баталсан "Улсын болон орон нутгийн төсөв, МУХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах журам", мэргэжлийн байгууллагаас гаргасан норм норматив, шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг авч үзэх;
 - 1.5.2. Төсвийн ерөнхийлөн захирагч, захиалагч яам, газар, аймаг, нийслэл төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг сонгож төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа хууль тогтоомжид заасан зарчмуудыг баримталсан эсэх;
 - 1.5.3. Тухайн санхүүгийн жилд шинээр эхлэхээр тооцож буй төсөл, арга хэмжээ, барилга байгууламж нь хайгуул, зураг төслийн ажил нь хийгдсэн, ач холбогдлоор эрэмбэлгдэн нэн шаардлагатай нь тогтоогдсон, инженерийн сүлжээний хангамжийн асуудал шийдэгдсэн, үр ашигтай нь техник эдийн засгийн тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажил эхлэх нөхцлийг хангасан эсэх;
 - 1.5.4. Төсвийн хөрөнгөөр хийх их засварын ажлыг төлөвлөхдөө тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох материалыг үндэслэсэн эсэх;
 - 1.5.5. Тухайн санхүүгийн жилд зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах тэргүүлэх ач холбогдол бүхий төслийн жагсаалтыг тусгайлан гаргасан эсэх;

- 1.5.6. Захиалагч яам, газар, аймаг нийслэлийн санхүүгийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй харилцан уялдсан, нэгдмэл эсэх;
 - 1.5.7. Захиалагч хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэлийг холбогдох хууль, журмын дагуу хянаж баталгаажуулсан эсэх;
 - 1.5.8. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, их засварын ажлыг санхүүжүүлэх үйл ажиллагаа нь холбогдох хууль, журмын дагуу явагдаж, зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх. Төсвийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилт батлагдсан хуваарь, нээгдсэн эрхийн дагуу санхүүжигдсэн эсэх;
 - 1.5.9. Захиалагч болон дээд шатны төсвийн эрх захирагч нь өөрийн шууд захиалгатай төсөл, арга хэмжээ, аймаг, нийслэлд гэрээгээр санхүүжилтийн эрх шилжүүлсэн барилга, их засварын ажлын гүйцэтгэл, санхүүжилт, ажлын явцад байнгын хяналт тавьж ажилласан эсэх;
 - 1.5.10. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьж ажиллаж байгаа байдал;
 - 1.5.11. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээ, ажлын явцын талаарх мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох байгууллагад хүргүүлж байсан эсэх;
 - 1.5.12. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан гүйцэтгэлийн эцсийн дүнгээр тухайн төсөл хэрэгжсэн төсөвт байгууллагын санхүүд бүртгэж, тайлан балансад бүрэн тусгасан эсэх;
 - 1.5.13. Тухайн төслийн тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж, ажил гүйцэтгэх гэрээ, ажлын гүйцэтгэл, нээсэн эрх, ашиглалтад хүлээн авсан комиссын акт, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгаа, төсөлтэй холбогдох бусад баримт, мэдээллийг зохих журмын дагуу архивын нэгж үүсгэн хадгалсан эсэх;
- 1.6. Төсөв хоорондын харилцааны талаар дараах байдлаар авч үзнэ. Үүнд:
- 1.6.1. Улс, орон нутгийн төсвийн хоорондын зохицуулалт, тэгшитгэл;
 - 1.6.2. Төсвийн хүрээний мэдэгдлийн хязгаарын мөрдөлт, Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн хязгаарын зохицуулалт;
 - 1.6.3. Монгол Улсын болон нэгдсэн төсвийн нэгтгэлийн үзүүлэлт, төсвийн тэнцэл, санхүүжүүлэх эх үүсвэрийн талаар;
 - 1.6.4. Улсын төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт;
 - 1.6.5. Татаас санхүүжилтийг зохих журмын дагуу олгож байгаа эсэх;
 - 1.6.6. Төсвийн нэгтгэлийн программ хангамжийн мөрдөлт;
 - 1.6.7. Төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах, төсвийн орлого, зарлагын бүтцийг оновчтой тогтоож, төсвийн тэнцвэржилтийг сайжруулах талаар УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийн биелэлт;
 - 1.6.8. Орон нутгийн ИТХ-аас баталсан төсвийг хэрэгжүүлэхэд УИХ, Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлт;

ТӨРИЙН САНГИЙН ДОТООД АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ /ЧИГЛЭЛ/

Төв болон орон нутгийн төрийн сан, Төсвийн ерөнхийлөн захирагчид, төсөвт байгууллагын төлбөр тооцооны гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтын байдалд дотоод аудит явуулахдаа

- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
- Нэгдсэн төсвийн тухай болон бусад төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомжууд
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Сангийн сайдын тушаалаар батлан, төсөв, санхүүгийн холбоотой харилцааг зохицуулахаар гаргасан журам, дүрэм, заавар зэрэг холбогдох бусад хууль эрхийн актын хүрээнд дараах байдлаар авч үзнэ.

1.1. Монгол Улсын төрийн сангийн үйл ажиллагаа, Засгийн газрын мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулалтын тооцоо хийх, гүйлгээ, санхүүжилт олгох, татах, данс бүртгэлд тусгах, гүйцэтгэлийн тайлан мэдээний үнэн зөв шуурхай байдал, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, заавар, журмын хэрэгжилт, төсвийн ил тод байдал, хяналт зэргийг үнэлж, дүгнэн, хөрөнгийн төлөвлөлт, удирдлагыг сайжруулах, эрсдэлийг бууруулах, илэрсэн зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгөх.

1.2. Дээр дурдсан хуулиуд болон бусад санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн мөрдөгдөж буй хууль тогтоомжууд, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журам зэрэг эрхийн актуудыг судлан үзэж, удирдамжид заасан үүргийг биелүүлэхэд зайлшгүй шаардагдах хууль эрхийн акт болон дотоод аудитад хамрагдах асуудлаа тодорхойлох.

1.3. Төрийн сангийн санхүүжилт, төлбөр тооцоо, данс бүртгэл, тайлагналтын үйл явцыг дараах байдлаар авч үзнэ.

- 1.3.1. Төрийн сан, төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүү мөнгөн хөрөнгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж буй бүтэц зохион байгуулалт, ажлын уялдаа холбоо, ажил үүргийн хуваарийг судлах;
- 1.3.2. Төрийн сангийн үйл ажиллагааны аюулгүй байдалд хэрхэн хяналт тавьж буй байдал. /Дохиолол, хяналтын систем, программ хангамжийн нууцлал, хадгалалт, устах аюул, баримтын бүрдэл, улсын мөнгөн хөрөнгийн нууцлал г.м/;
- 1.3.3. Төрийн сангийн нэгдсэн дансны ба улсын төсвийн харилцах дансны үлдэгдэл, Засгийн газрын тусгай сангууд, бусад мөнгөн хөрөнгийн урсгал гүйлгээний дүн мэдээг тулган хянах;
- 1.3.4. Төсвийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийг батлагдсан хуваарь, нээгдсэн эрхийн дагуу, зохих хугацаанд нь санхүүжүүлсэн эсэх;
- 1.3.5. Төсвийн санхүүжилтийн уян хатан байдлыг хангах үүднээс байгууллагын зайлшгүй нөхцөл байдлын улмаас зардлын эдийн

- засгийн ангилал хооронд сар, улирлын батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийсэн эсэх;
- 1.3.6. Улсын төсвөөс хөрөнгө оруулалт, их засвар, тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг зохицуулсан заавар журмын хэрэгжилт, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв бүртгэл хөтөлсөн эсэх;
 - 1.3.7. Төрийн сангийн төлбөр тооцооны баримтын бүрдэл;
 - 1.3.8. Төсвийн байгууллагын дансны орлого, зарлагын гүйлгээг бүртгэж, гүйлгээний баримтын бүрдлийг нягтлаж байгаа эсэх;
 - 1.3.9. Батлагдсан төсвийн зарцуулалтын эрхийн баталгааг үндэслэн хийсэн харилцагч төсвийн байгууллагын өдөр тутмын орлого, зарлагын гүйлгээг нэгбүрчлэн шалгаж, хяналт тавьж байгаа эсэх;
 - 1.3.10. Төрийн сангийн нэгдсэн дансанд бүртгэгдсэн төсөвт байгууллагуудын өдөр тутам хийгдэж байгаа орлого, зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн хуваарийн дагуу цаг хугацаанд нь, үнэн зөв бүртгэж, түүнд өдөр тутам хяналт тавьж байгаа эсэх, гүйлгээний залруулгыг шалгах;
 - 1.3.11. Төрийн сан ба банк хоорондын төлбөр тооцооны горим, түүнд хяналт тавьж байгаа байдал;
 - 1.3.12. Банк хоорондын төлбөр тооцооны өдөр тутмын үйл ажиллагааны хяналтыг гүйцэтгэж, гүйлгээг баталгаажуулсан байдал;
 - 1.3.13. Засгийн газрыг санхүүгийн удирдлагын мэдээллийн системийн нэгдсэн сүлжээнд холбогдсон төрийн сангийн нэгжүүдийн төлбөр тооцооны гүйлгээг банк хооронд дамжуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх ажлын явцыг давтан үзэх;
 - 1.3.14. Дотоод хяналтын системийг хянаж үнэлэлт дүгнэлт гаргасан байх;
 - 1.3.15. Төрийн сангийн ажилтнуудын ажлын зохион байгуулалт, ажил гүйцэтгэх чадвар, ажилтнуудын зан харилцаа, ажлын идэвхи санаачлага, цаг ашиглалт, харилцагч байгууллага иргэдтэй харилцах харилцаа зэргийг санал асуулга, судалгаа авах хэлбэрээр судлан дүгнэлт гаргах;
 - 1.3.16. Төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдлийн мэдээг үнэн зөв тогтмол гаргаж, мөнгөн хөрөнгийн урсгалыг зөв удирдаж засгийн газраас гаргасан бонд, хадгаламжийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийн тооцооллыг цаг тухайд нь хийж бүртгэлжүүлсэн эсэх;
 - 1.3.17. Монгол банкинд байршиж буй Төрийн сангийн нэгдсэн дансны орлого, зарлагын гүйлгээ болон арилжааны банкинд байршуулсан бэлэн мөнгөний харилцах дансны үлдэгдлийг өдөр тутам нийлж, өдрийн баримтанд хавсаргаж дансны хуулгыг үндэслэн гүйлгээ баланс гаргаж байгаа эсэх;
 - 1.3.18. Төрийн сангийн төгрөгийн болон гадаад валютын чөлөөт эх үүсвэрийн байршилт, Монгол банк болон арилжааны банкуудад байршуулахад баримтлах зарчмууд, арилжааны банкуудад олгосон зээл, мөнгөн хадгаламж, валютийн хадгаламж, үнэт цаас бүхий мөнгөн хадгаламж, Репо хэлцэл зэрэг нь холбогдох заавар журмын дагуу хийгдэж буй эсэх;
 - 1.3.19. Хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг хэрхэн тогтоосон байдал хүүг цаг хугацаанд нь данс бүртгэлд үнэн зөв тусгасан эсэх;
 - 1.3.20. Тэнцлийн гадуурх дансны бүртгэлийг шалгах;

Батлагдсан

- 1.3.21. Санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээлэлүүдийн найдвартай нөөцийн бүрэн бүтэн байдал ашиглагдаж байгаа программ хангамжийн зохистой ашиглалтын байдлыг хянах;
- 1.3.22. Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар аргачилал, санхүүгийн тайлангийн маягт аргачилалын талаар гаргасан Сангийн сайдын 2009 оны 137 тоот тушаалын биелэлтийг төрийн сан болон орон нутгийн төрийн санд хэрхэн хэрэгжүүлж байгааг байдал;
- 1.3.23. Монгол улсын төсвийн нэгдсэн тайлан тэнцлийг цаг хугацаанд нь үнэн зөв нэгтгэж аудитийн байгууллагаар баталгаажуулсан байдал, аудитийн дүгнэлт зөвлөмжийг залруулсан байдлыг шалгаж дүгнэлт зөвлөмж давхар гаргасан байна;

1.4. Гадаад, дотоодын зээл тусламж, өрийн удирдлагын талаар дараах байдлаар авч үзнэ.

- 1.4.1. Гадаад дотоодын зээл тусламжийн дансны өрийн үлдэгдлийг Засгийн газрын болон төсвийн нэгтгэсэн тайлангийн өр авлагын дансны үлдэгдэлтэй тулган шалгах, тооцоо нийлж баталгаажуулсан эсэх;
- 1.4.2. Өр авлага үүссэн гадаад орон, олон улсын байгууллага, Төсвийн ерөнхийлөн захирагч, аж ахуйн нэгж, байгууллагын нэр дээр хувийн хэрэг нээж баримтын бүрдлийг баталгаажуулсан байдал;
- 1.4.3. Томоохон дүнтэй гүйлгээнүүдээс түүвэрлэн авч гүйлгээнүүдийн анхан шатны баримт, төлбөр тооцооны шилжүүлэг, ирсэн гүйлгээний баримтыг үндэслэн хийгдсэн зэргийг тус тус шалгах;
- 1.4.4. Зээл, тусламжтай холбоотой гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн данс бүртгэлд бүрэн тусгасан эсэхийг ерөнхий журналтай тулган шалгаж, тохируулга хийсэн эсэх;
- 1.4.5. Зээлийн болон өрийн үлдэгдэлд хүү алданги тооцсон тооцооллыг гэрээний дагуу, үнэн зөв, цаг хугацаанд нь хийж, данс бүртгэлд тусгасан эсэх;
- 1.4.6. Зээлийн ангилал;
- 1.4.7. Зээлийг гэрээний биелэлт, зээлийн төлбөрийн цаг тухайд нь нэхэмжилж, барагдуулж байгаа болон хүүг хугацаанд нь хуримтлуулсан эсэх;
- 1.4.8. Монгол улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн талаар гарсан хууль тогтоолын биелэлт, түүний барагдалт;
- 1.4.9. Найдваргүй зээлийн өсөлт бууралт түүний шалтгааныг тодорхойлж дүгнэлт өгөх;
- 1.4.10. Зээлийн эрсдлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, судалгаа;
- 1.4.11. Гадаад орон олон улсын байгууллагаас авч ашиглаж байгаа зээл тусламжийн үр нөлөө, үр ашгийн талаар үнэлэлт дүгнэлтийг баримтад тулгуурлан өгөх;
- 1.4.12. Зээл тусламжийн хөрөнгөөр буй болсон хөрөнгө, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг данс бүртгэлд үнэн зөв тусгасан эсэх, орлогод бүртгэж үр ашигтай ажлуулж байгаа байдал;
- 1.4.13. Үнэт цаас, өрийн бичгийн үлдэгдэлийг шалгах;
- 1.4.14. Засгийн газраас гаргасан бондын эргэн төлөлт, хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьж буй байдал.

**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ДОТООД АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ /ЧИГЛЭЛ/**

Засгийн газрын худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийн дотоод аудитыг явуулахдаа:

- Нэгдсэн төсвийн тухай
- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай
- Тухайн оны төсвийн тухай хууль
- Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалаар батлагдсан Худалдан авах ажиллагаатай холбоотой холбоотой харилцааг зохицуулахаар гаргасан журам, дүрэм, заавар, мэргэжлийн байгууллагаас гаргасан норм норматив, шалгуур үзүүлэлтүүд зэрэг холбогдох бусад хууль эрхийн актын хүрээнд авч үзнэ.

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, ил тод байдал, тендерийн баримт бичиг боловсруулах, тендер зарлах, хүлээн авах, нээх, үнэлэх, гэрээ байгуулах зэрэг уг үйл ажиллагааны хэрэгжилтийг үе шат бүрээр нь дотоод аудит хийж, дүгнэлт өгөх, цаашид анхаарах болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр зөвлөгөө, удирдамжаар хангахад оршино.

1.2. Дээр дурдсан хуулиуд болон бусад худалдан авах ажиллагаатай холбоотой мөрдөгдөж буй хууль тогтоомжууд, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журам зэрэг эрхийн актуудыг судлан үзэж, удирдамжид заасан үүргийг биелүүлэхэд зайлшгүй шаардагдах хууль эрхийн акт болон дотоод аудитад хамрагдах асуудлаа тодорхойлох.

1.3. Худалдан авах ажиллагааны бэлтгэл үе шатыг зохих журмын дагуу зохион байгуулсан эсэхийг дараах байдлаар авч үзнэ. Үүнд:

- 1.3.1. "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг зохих хугацаад боловсруулж, батлуулсан эсэх
- 1.3.2. Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг төсвийн төлөвлөлттэй уялдсан эсэхийг холбогдох хууль, журмын заалтуудтай тулган үзэх.
- 1.3.3. Худалдан авах ажиллагааны хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа эхлүүлсэн эсэхийг хөрөнгийн эх үүсвэрийг баталсан хууль, тушаал, шийдвэрүүдтэй харьцуулан авч үзэх.
- 1.3.4. Үнэлгээний хороо байгуулсан эсэхийг захиалагчийн үнэлгээний хороо байгуулсан тушаал, үнэлгээний хорооны гиүүд шаардлага хангасан эсэх
- 1.3.5. Захиалагч нээлттэй тендер шалгаруулалтын журмаас бусад журмыг ашигласан бол үндэслэл бодиттой эсэх;

Батлагдсан

- 1.3.6. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа зохих тендерийн жишиг баримт бичгийг ашигласан эсэхийг авч үзэх.
 - 1.3.7. Тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод хязгаарлалт тогтоосон нөхцөл, заалт оруулсан эсэхийг авч үзэх.
- 1.4. Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын үе шатыг зохих журмын дагуу зохион байгуулсан эсэхийг дараах байдлаар авч үзнэ. Үүнд:
- 1.4.1. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тендерийн баримт бичигт гарсан зөрчлийг арилгахыг шаардсан тохиолдолд захиалагч түүний дагуу тендерийн баримт бичигт холбогдох өөрчлөлтийг оруулсан эсэхийг авч үзэх;
 - 1.4.2. Захиалагч урьдчилсан сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу явуулсан эсэх, урьдчилсан сонгон шалгаруулалтын үндэслэл бодитой эсэхийг авч үзэх;
 - 1.4.3. Тендер шалгаруулах урилгыг олон нийтэд ил тод зарласан эсэхийг холбогдох сонин, хэвлэлд зарлагдсан тендерийн урилгатай тулгаж үзэх;
 - 1.4.4. Хуульд заасан босго үнээс давсан тендер шалгаруулалтын урилгыг цахим хуудаст нийтэлсэн эсэхийг шалгаж үзэх;
 - 1.4.5. Тендерийг хуульд заасан хугацаанд нээсэн эсэхийг тендерийн нээлтийн тэмдэглэлтэй тулган авч үзэх, тендерийн хүчинтэй хугацааг сунгасан эсэх;
 - 1.4.6. Гэрээ байгуулахдаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан эсэхийг үзэх;
 - 1.4.7. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас үнэлгээний явцад гарсан зөрчлийг арилгаж, үнэлгээг дахин хийхийг шаардсан тохиолдолд захиалагч үнэлгээг хууль, журмын дагуу дахин хийж, зөрчлийг арилгасан эсэхийг авч үзэх;
 - 1.4.8. Тендерийн үр дүнг олон нийтэд мэдээлсэн эсэхийг шалгах, "Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээнд тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээллэх журам"-ыг мөрдсөн эсэхийг үзэх;
 - 1.4.9. Тендер шалгаруулах явцад гарсан гомдлыг хуулийн хугацаанд зохих журмын дагуу шийдвэрлэсэн эсэхийг.
- 1.5. Худалдан авах ажиллагааны Гэрээ байгуулах, хэрэгжүүлэх үе шатыг зохих журмын дагуу зохион байгуулсан эсэхийг дараах байдлаар авч үзнэ. Үүнд:
- 1.5.1. Шалгарсан тендерт оролцогчийн тендерийн үнээр гэрээ байгуулсан, үнийн дүнд өөрчлөлт орсон бол үндэслэлийг нягтлах;
 - 1.5.2. Гэрээг цаг хугацаанд нь хэрэгжүүлсэн эсэх, хэрэв гэрээний хугацааг сунгасан бол үндэслэл нь хэр бодитой болохийг авч үзэх;
 - 1.5.3. Гэрээний биелэлт, техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээнд заасны дагуу чанартай хийгдсэн эсэхийг авч үзэх;
 - 1.5.4. Гэрээний төлбөр тооцоог гэрээнд заасны дагуу бүрэн хийсэн эсэхийг гэрээний баримт бичиг, данс, бүртгэл, гүйлгээтэй харьцуулан шалгаж үзэх;
 - 1.5.5. Гэрээг дүгнэж, хүлээж авсан акт байгаа эсэхийг шалгаж үзэх;

1.6. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг дараах байдлаар авч үзнэ.
Үүнд:

- 1.6.1. ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ бүгд хугацаандаа хэрэгжсэн эсэхийг ХАА-ны төлөвлөгөө, тайланг тулган шалгаж үзэх;
- 1.6.2. Төсөл, арга хэмжээ хойшлогдсон бол үндэслэлтэй эсэхийг нь авч үзэх;
- 1.6.3. Барилга, засвар, угсралт, зам зэрэг улирлын шинж чанартай ажлуудыг хэрэгжүүлсэн эсэхийг үзэх;
- 1.6.4. ХАА-нд шууд гэрээ байгуулах аргыг сонгосон бол үндэслэлийг, гэрээний хувийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн эсэхийг авч үзэх;
- 1.6.5. ХАА-ны тайлагналт нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг тайлагнах журам"-д заасан маягтын дагуу бэлтгэсэн эсэх;

---oOo---

面談記録

日 時	2011年9月5日 12:00～13:00	
相手国機関	Fiscal Policy Dept., MOF (大蔵省 財政政策局)	
場 所	大蔵省 財政政策局	
出席者	モンゴル側	Mr. B. Nyamaa (Head of Expenditure Division, Fiscal Policy Dept., MOF)
	日本側	JICA: サイハナ、竹鶴、 コンサルタント: 遠藤、大供
	その他	Mr. Erdene (C/P)、通訳: ダワ氏
協議内容		
【内部監査、IA-ME Dept.の活動について】		
<ul style="list-style-type: none"> ▪ 当局の活動に対しては、IA-ME Dept.が、モニタリングとして毎月のレビューを実施。 ▪ 内部監査は、元々はリスクの大きい Treasury に関する内部監査を重点的に行うものと考えていたが、予算計画のプログラムに対しても、内部監査は必要と考えている。 ▪ 当局では、予算計画の際に Line Ministry から予算要求書類を受け取るが、内部監査（モニタリング）の結果も含まれており、IA-ME Dept.ともその情報を共有している。当局では、月次の計画・実施状況や改善計画などの実施状況もレビューし、参考にしている。 ▪ 大蔵省での内部監査の指摘事項については、IA-ME Dept.から監査委員会、監査委員会から副大臣、大臣へと報告されて、そこから各部への指示等が出される。 ▪ 当局の業務に関連する指摘事項であっても、法・規則等の改正が必要なものは現実的には対応が困難である。また大蔵省外に及ぶ事項についても対応困難なものが多い。 ▪ 現在の内部監査が抱える問題としては、人員不足がある。現地訓練による能力強化は有効ではないか。また内部監査人には、予算サイドや執行サイドの業務経験があると有効であると考えている。 ▪ 大蔵省の各局でリスク分析を実施、当局でもリスクの文書を作成し、IA-ME Dept.に提出した。当局の業務は、担当者の欠員等のリスクが大きいと考えられ、その対策として担当者のローテーション等を実施している。IT システムについてもリスクは認識しているが、現在の IA-ME Dept.の内部監査人では対応が困難と思われる。 		
【内部監査に対する認識】		
<ul style="list-style-type: none"> ▪ 元々、1990年代前半に各省に設置されていた検査機能が、State Inspection Agency (SIA) として2000年代に統合された。新予算法案では、内部監査の機能として、再び分権化されるものと考えている。 ▪ 流用や横領などの不正の発生も報告されているが、各省でのモニタリング機能が不十分であったために、早期の検出ができなかったと思われるため、各省の内部監査機能を充実させるニーズはある。 ▪ 予算サイドの分野では、計画と実施の不整合などのリスクについて、内部監査による改善提案などを期待している。 ▪ 当局では、内部監査に対する認識はあり、内部監査人にも協力している。当局のすべてのスタッフの予算計画策定にかかる意思決定の妥当性等を上位者がチェックすることは不可能であるため、サンプルベースで詳細なチェックを行っているが、内部監査でもチェックがあれば有効であると考えている。 ▪ 内部監査には、検査や外部監査のような「事後的な」監査・検査ではなく、「予防的な」監査や、不正等の予防策の提案などを期待したい。 		
【プロジェクトのアプローチ】		
<ul style="list-style-type: none"> ▪ 内部監査人に専門家が同行して OJT を実施することについては、特に問題はない。 ▪ 中央銀行での内部監査の方法等は参考になるかもしれないので、協力してもらうことも考えられるのではないか。 		

日 時	2011年9月5日 14:00～16:00	
相手国機関	Internal Auditing, Monitoring & Evaluation Dept., MOF (大蔵省内部監査・業績評価モニタリング局)	
場 所	大蔵省 会議室 (9F)	
出席者	モンゴル側	Ms. B. Gerelmaa (Director General), Mr. Bayanmunkh, Mr. Erdene (Internal Auditing, Monitoring and Evaluation Dept., MOF)
	日本側	JICA: サイハナ、竹鶴、 コンサルタント: 遠藤、大供
	その他	通訳: ダワ氏
協議内容		
<p>【C/P が本プロジェクトの成果として期待するところ】</p> <ul style="list-style-type: none"> ▪ 内部監査能力の向上 (大蔵省、省庁、地方も含めて) ▪ 各省庁、地方の内部監査体制の向上 (大蔵省実施の内部監査を地方に展開するための支援) ▪ 法的整備の支援 ▪ 内部監査中長期戦略の策定支援 (地方の監査体制構築支援含む) ▪ ガイドライン、ルール制定の支援 (WB が法整備をやって、JICA はその実施・定着を支援するイメージを C/P は持っている) ▪ IT 監査技術の提供 (国庫の IT システムに IT 監査を導入する必要がある) ▪ 外国融資、調達活動などについての、監査指導書 (監査プログラム) の作成支援 ▪ 内部監査の研修プログラムの作成支援 (WB の作ったルールをインプリするための研修含む) ▪ IPPF, RISK Management Standard の翻訳 ▪ 機材の提供 (コピー機、ノート PC、プリンター、プロジェクター等研修機材) ▪ 各 Portfolio Minister での内部監査機能の充実と人材育成 (社会福祉労働省、教育省、軽産業食糧農牧省の3省が候補) <p>【CP の内部監査構築スキーム】</p> <ul style="list-style-type: none"> ▪ まずは大蔵省を固めてから各省庁、それから地方に展開したい。 ▪ 予算の策定から配分に至るプロセスに対する内部監査から導入したい (予算執行に関しては、実証的 (事後的) な外部監査・検査を NAO、SIA が実施、内部監査では「予防的」な監査に重点を置きたい)。 ▪ 予算策定担当者、承認者、出納担当等の共謀による横領事例があり、不正防止を範疇に入れた内部監査をデザインする必要がある。 ▪ リスクベースによる内部監査の仕組みを構築して効率化を図りたい。 <p>【その他】</p> <ul style="list-style-type: none"> ▪ 経済規模の拡大に伴い、また地方の権限が拡大しているところ、地方自治体の自律的な財政管理体制の拡充が必要になり、内部監査の強化が必要になっている。従って、地方政府においても、内部監査の専門家の配置、内部監査能力の強化が必要。 ▪ 国際的な基準や実務に適合した内部監査の仕組みをモンゴルの公的機関にも導入したい。 ▪ 日本のガバメントセクターの内部監査事例を生かしたい。 ▪ JICA と WB の関係については、双方の整合性を確保してプロジェクトを進めていきたい。 ▪ WB のプロジェクトでは、大蔵省内の体制整備やルールづくりを計画しており、JICA には、各省・地方政府へのそれらのルール等の普及・定着を支援して頂きたい。 ▪ 中長期的戦略 (計画) では、各省・地方政府へいかに普及するかについての、法的環境や体制強化、 		

専門家（内部監査人の意味）育成のための計画などを作成したいので、その支援をお願いしたい。

- NAO の指摘においても、公的機関での内部統制の体制構築が指摘されていることから、内部監査の果たす役割はあるものと思われる。

（面談者注：ただし、内部監査と内部統制は、必ずしも明確に区別して認識されている訳ではない。）

- NAO、SIA と内部監査との業務の重複は考えられるため、引き続き議論が必要。


【プロジェクトのアプローチ】

- 省としても、また局としても、全面的にプロジェクトには協力する。
- 局としても、各省や地方政府に対する研修等についても、調整は責任をもって行う。

【新予算法案について】

- 国会の通過はほぼ確実であると思われる。
- 新予算法案などの法律の動きに、今回のプロジェクトによる内部監査支援活動は左右されないので安心してほしい。現行法で実施可能な活動である。

【C/P の想定する内部監査体制のイメージ】



日 時	2011 年 9 月 5 日 16:00～17:00	
相手国機関	Accounting Policy Dept., MOF (大蔵省 会計政策局)	
場 所	大蔵省会議室 (9F)	
出席者	モンゴル側	Mr. S. Myagmardash (Director, Accounting Policy Dept., MOF)
	日本側	JICA: サイハナ、 コンサルタント: 遠藤、大供
	その他	Mr. Erdene (C/P)、通訳: ダワ氏
協議内容		
